

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 7354 дүгээрт бүртгэв.*

## **БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

2025 оны 7 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар А/657, А/256

Булган сум

### **АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2 дахь заалт, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААН/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Булган аймгийн төв Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг 1 дүгээр, бүсэд мөрдөх журмыг 2 дугаар, бүсийн хилийн зааг, байршлыг харуулсан зургийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү хамтарсан тушаал, захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газар (Г.Энхмөнх)-т, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Булган аймгийн Байгаль орчны газар (А.Гантөмөр), Ус цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Нандинбат), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д тус тус даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр), Булган аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү хамтарсан тушаал, захирамж гарсантай холбогдуулан “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Булган аймгийн Засаг даргын 2018 оны А/364, А/548 дугаар хамтарсан тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Б.БАТБААТАР

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн  
А/657, А/256 дугаар тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт*

**БУЛГАН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

Агаарын чанарыг сайжруулах бүс	Бүсэд хамрагдах газрын байршил, багууд	Гэр хорооллын айл өрх	Орон сууцны айл өрх	Аж ахуй нэгж
Агаарын чанарыг сайжруулах 1-р бүс	1, 2, 3, 4, 5, 6 дугаар багуудын гэр хорооллын айл өрхүүд (нүүрэн талын 1-5-р гудамжны гэр хорооллын айл өрх) болон багийн ААН-үүд	615	515	30
Агаарын чанарыг сайжруулах 2-р бүс	5 дугаар баг, 2 ба 4 дүгээр баг, шинэ хороо, зүүн түүрүү, хожуу ухаарлын айл өрхүүд (6-р гудамжнаас хойших айл өрхүүд), аймгийн төвийн албан байгууллагууд хамаарна.	2809		33
Нийт өрхийн тоо		3,922		

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн  
А/657, А/256 дугаар тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт*

## **БУЛГАН АЙМГИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС, БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэ журмын зорилго нь Булган аймгийн төв Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг Булган аймгийн төв болон Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### **ХОЁР.ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

Булган аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж амьдарч буй иргэн, аж ахуй нэгж байгууллага Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

#### **2.1.Агаарын чанарыг сайжруулах 1 дүгээр бүс**

2.1.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус цаг уур, орчны шинжилгээний төв болон холбогдох мэргэжлийн байгууллага (Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Эрдэнэт Булганы Цахилгаан түгээх төрийн өмчит сүлжээ ХХК, Булган Мээж ТӨХК гм)-аар дүгнэлт гаргуулан Булган сумын Засаг даргаас зөвшөөрөл авна;

2.1.2.Угаарын хийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын чанарын бүсэд байрлах түр болон байнгын оршин суугч гэр хорооллын айл өрхүүдэд яндангаа хөөлөх, зуухаа сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

2.1.3.Агаарын чанарын сайжруулах бүсэд халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд технологийн шинэчлэл хийж сайжруулах, шаталтыг бүрэн явуулах, бохирдлыг бууруулах зорилгоор (тортог баригч, шүүлтүүр, утаа сарниулагч суурилуулах, зуухны янданг боломжит хамгийн өндөр хэмжээнд хүртэл өндөрлөх гэх мэт) тоноглох;

2.1.4.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших түргэн үйлчилгээний цэг, дугуй засвар, харуулын байр, автомашины засвар, угаалгын газрууд зориулалтын бус түлш буюу хаягдал дугуй, ашигласан тос масло, хуванцар болон нийлэг уут гэх мэт хог хаягдлыг шатаахгүй

байх;

2.1.5.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах иргэн 5-аас доошгүй, аж ахуй нэгж байгууллагууд 10-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

2.1.6.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хашаандаа хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэд оруулах;

2.1.7.Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.1.8.Агаарын чанарыг сайжруулах бүсэд аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгаа, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;

2.1.9.Агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламжийг “Нүхэн жорлон, угаадасны нүх” техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

2.1.10.Уурын болон усан халаалтын зуух хэрэглэдэг аж ахуйн нэгж байгууллагууд үнс баригч, шүүлтүүртэй зуух суурилуулах, үнс, нурам ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах (чийгшүүлэх) арга хэмжээ авах;

2.1.11.Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд өдөр, шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (гэр, байшин, барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглэндээ үе шаттайгаар нэвтрүүлэх;

2.1.12.Байгаль орчны газрын байцаагч болон цагдаагийн газрын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

2.1.13.Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

2.1.14.Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15 кв хүртэлх хүчин чадалтай зуухны тоог нэмэгдүүлэхгүй байх;

2.1.15.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүд 15-100 квт хүртэлх хүчин чадалтай зууханд технологийн шинэчлэлт хийх /хийн болон цахилгаан/;

2.1.16. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий Хүхрийн давхар исэл, Азотын давхар исэл, Тоосонцор шүүх шүүлтүүрүүдийг суурилуулах;

2.1.17. Агаарын чанарыг сайжруулах бүсэд гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

2.2. Агаарын чанарыг сайжруулах 2 дугаар бүс

2.2.1. Агаарын чанарыг сайжруулах 1 дүгээр бүсийн бохирдлын дам нөлөөлөлд өртдөг тул түүхий нүүрс түлэх, бүх төрлийн шатаах зуух ашиглахыг хориглох;

2.2.2. Зөвхөн стандартын шаардлага хангасан эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмж ашиглуулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.3. Агаарын бохирдол ихтэй өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг хийх;

2.2.4. Агаарын чанарыг сайжруулах 1 ба 2-р бүсэд Стандартын шаардлага хангаагүй цахилгаан (гар аргаар хийсэн тенг, утааны шүүлтүүргүй шатаах зуух) халаалтын хэрэгслийг ашиглахыг хориглох;

### **ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ**

3.1. Булган аймгийн Булган сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2. Аймгийн Байгаль орчны газар, Булган сумын Засаг даргын Тамгын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг биелүүлж ажиллана.

3.3. Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

3.4. Ус цаг уур орчны шинжилгээний төв нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орших агаар бохирдуулах эх үүсвэрийн мэдээлэл болон агаарын чанарын төлөв байдлын талаарх тайлан мэдээг Байгаль орчны газар, Булган сумын Засаг даргын Тамгын газарт хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

3.5. Байгаль орчны газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5.1. Байгаль орчны газар Булган сумын Засаг даргын Тамгын газартай хамтран журмын хэрэгжилтийн талаар холбогдох мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын

газарт тайлагнана;

3.5.2.“Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана;

3.5.3.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг Эрүүл мэндийн газар, Булган сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.


### **ДӨРӨВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Булган аймгийн Байгаль орчны газар, Булган сумын Засаг даргын Тамгын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга нар хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ноогдуулна.

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн  
А/657, А/256 дугаар тушаал, захирамжийн 3 дугаар хавсралт*

## **БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСИЙН ХИЛИЙН ЗААГ, БАЙРШЛЫГ ХАРУУЛСАН ГАЗРЫН ЗУРАГ**





Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 7355 дугаарт бүртгэв.

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД,  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ,  
ЗАХИРАМЖ**

2025 оны 8 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар А/672, А/398

Сүхбаатар сум

**АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС ТОГТООХ, БҮСЭД  
МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Агаарын чанарыг сайжруулах бүсийг 1 дүгээр, бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал, захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар /Г.Энхмөнх/, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын дарга /З.Түвшинтөгс/, Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга /О.Ганбат/, Мандал сумын Засаг дарга /Д.Хадбаатар/, Сайхан сумын Засаг дарга /Б.Мөнхтөр/, Сүхбаатар сумын Засаг даргад тус тус даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчны газрын дарга /З.Түвшинтөгс/, Мандал сумын Засаг дарга /Д.Хадбаатар/, Сайхан сумын Засаг дарга /Б.Мөнхтөр/, Сүхбаатар сумын Засаг даргад тус тус үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Б.БАТБААТАР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Н.ЛХАГВАДОРЖ

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сэлэнгэ аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн  
А/672, А/398 дугаар тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт*

### **МАНДАЛ СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

Агаарын чанарыг сайжруулах бүс	Бүсэд хамрагдах багууд	Гэр хорооллын айл өрх	Орон сууцны айл өрх
1-р бүс Мандал сумын гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага хамаарна.	2, 3, 4, 6, 7, 9 дүгээр багууд	4080	742

### **САЙХАН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

Агаарын чанарыг сайжруулах бүс	Бүсэд хамрагдах багууд	Гэр хорооллын айл өрх	Орон сууцны айл өрх
2-р бүс Сайхан сумын гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага хамаарна.	1, 2, 3, 4 дүгээр багууд	1463	1301

### **СҮХБААТАР СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

Агаарын чанарыг сайжруулах бүс	Бүсэд хамрагдах багууд	Гэр хорооллын айл өрх	Орон сууцны айл өрх
3-р бүс Сүхбаатар сумын гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага хамаарна.	1, 3, 4, 5, 8 дугаар багууд	3639	174

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сэлэнгэ аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн  
А/672, А/398 дугаар тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт*

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Сэлэнгэ аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг Сэлэнгэ аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### **Хоёр.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

2.2.Агаарын чанарыг сайжруулах бүсэд халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд технологийн шинэчлэл хийж сайжруулах, шаталтыг бүрэн явуулах, бохирдлыг бууруулах зорилгоор /тортог баригч шүүлтүүр, утаа сарниулагч суурилуулах, зуухны янданг боломжит хамгийн өндөр хэмжээнд хүртэл өндөрлөх г.м/ тоноглох.

2.3.Уурын болон усан халаалтын зуух хэрэглэдэг аж ахуйн нэгж, байгууллагууд зуух, яндангийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийж, үнс, нурам ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах, чийгшүүлэх арга хэмжээ авах.

2.4.Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага халаалтын зууханд хаягдал дугуй, ашигласан масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт зориулалтын бус түлш шатаахгүй байх.

2.5.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах иргэн 5-аас доошгүй, аж ахуйн нэгж байгууллагууд 10-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

2.6.Агаарын чанарыг сайжруулах бүсэд аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох.

2.7.Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч

хэрэгжүүлэх.

2.8. Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших.

2.9. Гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламжаа нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх.

2.10. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд өдөр шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (гэр, байшин барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглээндээ үе шаттайгаар нэвтрүүлэх.

2.11. Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

2.12. Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

2.13. Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15 кв хүртэлх хүчин чадалтай зуухны тоог нэмэгдүүлэхгүй байх.

2.14. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүд 15-100 кв хүртэлх хүчин чадалтай зууханд технологийн шинэчлэлт хийх /хийн болон цахилгаан/.

2.15. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий хүхрийн давхар исэл, Азотын давхар исэл, тоосонцор шүүх шүүлтүүрүүдийг суурилуулах.

2.16. Агаарын чанарыг сайжруулах бүсэд гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн дулаалга хийх.

### **Гурав. Төрийн байгууллагуудын чиг үүрэг**

3.1. Сэлэнгэ аймгийн сумдын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2. Аймгийн Байгаль орчны газар, сумдын Засаг даргын Тамгын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.3. Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд

хүргүүлнэ.

3.4.УЦУОШТөв нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орших агаар бохирдуулах эх үүсвэрийн мэдээлэл болон агаарын чанарын төлөв байдлын талаарх тайлан мэдээг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

3.5.Байгаль орчин, аялал жуулчлалын газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:


3.5.1.“Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана;


3.5.3.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг, Эрүүл мэндийн газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.


#### **Дөрөв.Хяналт, хариуцлага**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газар /Ус цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга нар/ хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг), төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ноогдуулна.









*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 7356 дугаарт бүртгэв.*

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД,  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ,  
ЗАХИРАМЖ**

2025 оны 9 дүгээр  
сарын 03-ны өдөр

Дугаар А/704, А/439

Дархан-Уул аймаг

**АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС ТОГТООХ, БҮСЭД  
МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Дархан-Уул аймгийн агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг 1 дүгээр, бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаал, захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны, бодлого үнэлгээний газар /Г.Энхмөнх/-т, журмын хэрэгжилтийг хангуулж, явц, үр дүнг тайлагнаж ажиллахыг Байгаль орчны газар /Г.Батбаяр/-т, Ус цаг уур, орчны шинжилгээний төв /С.Алтандолгион/-д, Дархан сумын Засаг дарга /Т.Тулгаа/, Шарын гол сумын Засаг дарга /М.Мөнхбаяр/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс /П.Батсүх/-т нарт үүрэг даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, таниулах ажлыг Байгаль орчны газар /Г.Батбаяр/-т, Дархан, Шарын гол сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ хамтарсан тушаал, захирамж гарсантай холбогдуулан “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/505, 01-А/305 хамтарсан тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Б.БАТБААТАР

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/704, А/439 дүгээр тушаал, захирамжийн нэгдүгээр хавсралт*

### **ДАРХАН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

Бүс	Бүсэд хамрагдах баг	Өрхийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
1-р бүс	Дархан сумын 1, 2, 3, 5, 6, 7, 8, 15, Малчин баг	6525	Дархан сум-38

### **ШАРЫН ГОЛ СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

Бүс	Бүсэд хамрагдах баг	Өрхийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
1-р бүс	Шарын гол сумын төвийн Дархан, Хайрхан, Санжид баг	624	Шарын гол сум-3

Тайлбар: Дархан сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоохдоо ЦУОШТ-ын 2017-2025 оны Агаарын чанарын хяналт мониторингийн тайлан, Дархан-Уул аймгийн Агаарын чанарын нарийвчилсан үнэлгээний тайлан, 2017-2025 оны Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого, эрдэмтдийн судалгааны бүтээл, иргэдийн саналыг үндэслэн боловсруулав.

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/704, А/439 дүгээр тушаал, захирамжийн хоёрдугаар хавсралт*

## **АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэ журмын зорилго нь Дархан, Шарын гол сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.3.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга нар хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

1.4.Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино.

### **ХОЁР.АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД ХАМААРАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

Дархан-Уул аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

2.2.Агаар хамгаалах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд айл өрх хашаандаа 5-с доошгүй жимс, жимсгэнийн мод, аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшлийн газрын 10%-с доошгүй талбайд ногоон байгууламж байгуулсан байх, тухайлан заасан байршилд зүлэг, мод тарьж ургуулсан тохиолдолд 1м<sup>2</sup> талбайд төрөөс урамшуулал авах.

2.3.Агаарын бохирдол ихтэй өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалуулах.

2.4.Агаарын чанарын “MNS4585:2016” стандартад нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан болон хийн халаагч төхөөрөмжийг үе шаттай хэрэглээнд нэвтрүүлэх.

2.5.Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд аймаг, сумаас зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох.

2.6. Гэр хорооллын айл өрх ариун цэврийн байгууламжаа сайжруулж хөрсөнд үл нэвчих байгальд ээлтэй био ариун цэврийн байгууламжийг ашиглах.

2.7. Гэр хорооллын айл өрх үнс, хог хаягдлыг хадгалах зориулалтын цэгт цуглуулах, тээвэрлэлтэд зориулж савлаж бэлтгэсэн байх.

2.8. Шинээр газар эзэмшсэн болон газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь эзэмшсэн болон шилжүүлж авсан газрынхаа 10%-тай тэнцэх талбайд болон тусгайлан заасан газарт ногоон байгууламж бий болгох.

2.9. Аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдол, хог хаягдал орчны бохирдлыг бууруулах үүрэгтэй бөгөөд байгаль орчны ажилтантай байх.

2.10. Аж ахуйн нэгж байгууллага нь орчны ногоон байгууламжаа хамгаалах, арчилж ургуулах, ногоон байгууламжгүй бол өөрийн эзэмшиж буй нийт талбайн арваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний газарт ногоон байгууламжийг бий болгох ажлыг зохион байгуулах.

2.11. Үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага, дугуй засвар, харуулын байр, автомашины засвар угаалгын үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн дулааны эх үүсвэрт хяналт тавьж, халаалтын зууханд хаягдал дугуй, ажилласан масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт хаягдал зүйлс шатаахгүй байх.

2.12. Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15квт хүртэлх хүчин чадалтай зуухны тоог нэмэгдүүлэхгүй байх.

2.13. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүд 15-100 квт хүртэлх хүчин чадалтай зууханд технологийн шинэчлэлт хийх /хийн болон цахилгаан гэх мэт/.

2.14. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий Хүхрийн давхар исэл, Азотын давхар исэл, Тоосонцор шүүх шүүлтүүрүүдийг суурилуулах.

2.15. Агаарын чанарыг сайжруулах бүсэд гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

2.16. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаар эрх бүхий этгээдэд үнэн зөв мэдээлэх.

2.17. Агаарын тухай хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, бүх шатны Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, Багийн Засаг дарга, хэсгийн ахлагчийн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

## **ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр төрийн байгууллагууд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр:

3.1.1. Агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах төсвийн төслийг боловсруулж, тухайн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

3.1.2. Агаарын тухай хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнгийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлэх, агаарын чанарыг сайжруулах бүсийн хилийн зааг, байршлыг харуулсан 1:25000-ас доошгүй масштаб бүхий газрын зургийг олон нийтэд нээлттэй байршуулах;

3.1.3. Иргэд тухайлан заасан байршилд зүлэг, мод тарьж ургуулсан тохиолдолд урамшуулал олгох ажлыг зохион байгуулах;

3.1.4. Агаарын тухай хууль, энэ журмын хэрэгжилтийг хангуулж эрчим хүчний эх үүсвэр, гэр хорооллын цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх;

3.1.5. Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн орон нутгийн тооллогыг конвенцын талуудын бага хурлаар баталсан арга зүйн дагуу зохион байгуулж явуулах;

3.1.6. Агаарын чанарын орон нутгийн албыг байгуулан ажиллуулах;

3.1.7. Агаарын бохирдлыг бууруулахад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, шинэ санаачилга гаргасан өрх, аж ахуйн нэгж, байгууллагад орон нутгийг хөгжүүлэх сангаас дэмжлэг үзүүлэх;

3.1.8. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад өдөр, шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах нөхцөлийг хангах, техникийн нөхцөлийг бүрдүүлэх.

3.2. Байгаль орчны газрын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд шинээр газар эзэмшсэн болон газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн иргэн, ААНБ, ТББ-ууд эзэмшсэн болон шилжүүлж авсан газрынхаа 10%-тай тэнцэх талбайд болон тусгайлан заасан газарт ногоон байгууламж бий болгох ажилд хяналт тавьж, арга зүйн зөвлөмжөөр хангах;

3.2.2. Иргэдийн тогтвортой хөгжлийн боловсролыг сайжруулах хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон эцэг, эхчүүдэд зориулан агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах сургалтыг тогтмол зохион байгуулах;

3.2.3. Шинээр төрсөн хүүхдэд зориулсан “Шинэ иргэний төгөл”

газарт эцэг, эхчүүд шинээр төрсөн хүүхдэдээ зориулж мод бут тарихад дэмжлэг үзүүлж, тусгайлан бэлтгэсэн мод тарих газрыг зааж өгөх ажлыг зохион байгуулах;

3.2.4. Айл өрхөд гэр, орон сууцны дулааны алдагдлыг бууруулахад чиглэсэн “Яндангаа хөөлье”, “Гэр, байшингийн дулааны алдагдлыг бууруулъя”, “Эрүүл мэнд, цэвэр агаар” зэрэг агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн сургалтыг, аж ахуйн нэгж, байгууллагад “Хог хаягдлын менежмент”, “Уур амьсгалын өөрчлөлт”, “Ногоон технологи-байгальд ээлтэй шийдэл” зэрэг байгаль орчны мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

3.2.5. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагатай хамтран бүс тогтоох, бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулж, мөрдүүлэх.

3.3. Ус цаг уур, орчны шинжилгээний төв, “Дархан дахин төлөвлөлт” ААТҮГ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.3.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, хуулийн этгээдийн талаар мэдээллийн сан байгуулж, хөтлөлт явуулах;

3.3.2. Агаарын тухай хууль тогтоомж болон энэ журмын хэрэгжилтийг хангаж сорьц дээж авах, судалгаа шинжилгээний ажил явуулах, явц, үр дүнгийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлж ажиллах.

3.4. Автотээврийн төвийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.4.1. Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр буюу автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс үүдэлтэй агаар орчны бохирдлыг хянаж, бүртгэл хөтлөх, стандартыг хангуулах;

3.4.2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч, дугуй засвар, авто худалдаа, авто угаалга зэрэг үйлчилгээний байгууллагуудыг бүртгэлжүүлж, агаар орчны бохирдол үүсгэхгүй байх, хяналтыг тавьж ажиллах;

3.4.3. Хөдөлгөөнт эх үүсвэрийн насжилтаас хамаарч 10-с дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэлд улсын дугаар олгохгүй байх, замын хөдөлгөөнд орохыг хязгаарлах арга хэмжээг Замын цагдаа, Тээврийн Цагдаагийн албатай хамтран зохион байгуулах;

3.4.4. Тээврийн хэрэгслээс үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, хадгалах, устгах үйл ажиллагааг хянах, бүртгэх.

3.5. Экологийн Цагдаагийн албаны хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.5.1. Журмын хэрэгжилтийг хангах ажлыг бусад төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.5.2. Хүн ам, байгаль орчинд сөргөөр нөлөөлж буй аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ, тэдгээрт дангаар болон төрийн бусад

байгууллагатай хамтран хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх.

3.6.Төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.6.1.Иргэд, байгууллагуудад агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр уриалга гаргаж, сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг явуулах;

3.6.2.Төрийн байгууллагын зарим ажил арга хэмжээг Төр хувийн хэвшлийн түншлэлийн журмын дагуу хэрэгжүүлэх;

3.6.3.Төсөл хөтөлбөр, төрийн байгууллагаас явуулсан арга хэмжээнд хамрагдаж, чадавх хүний нөөцөө бэхжүүлэх улмаар агаарын чанарын сайжруулах бүсийн дэглэмийг мөрдүүлэхэд нөлөөллийн ажлыг гүйцэтгэх.

### **ДӨРӨВ.ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Цагдаагийн газрын Экологийн Цагдаагийн алба, Автотээврийн төв, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга, хэсгийн ахлагч нар хяналт тавина.

4.2.Сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв журмын хэрэгжилтийн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд гаргаж, холбогдох байгууллагуудад тайлагнаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэнэ.

### **ТАВ.ХАРИУЦЛАГА**

5.1.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль /Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг/, Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.



Захиргааны хэм хэмжээний актын улсын нээгдсэн бүртгэлд  
2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 7357 дугаарт бүртгэв.

## СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 01

Хонгор

### МАЛЫН ТОО, ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.2023-2024 онуудад байгаль цаг агаарын хүнд нөхцөл байдлын улмаас өвөлжилт, хаваржилт хүндэрч мал их хэмжээгээр хорогдсон, малчдын амьжиргаа хүндэрсэн тул малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоосугай.

2.Малын тоо, толгойн албан татварын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Малын тоо толгойн албан татвартай холбоотой ажлыг хууль журмын дагуу хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (М.Ганхөлөг), Татварын улсын байцаагч (Н.Энхцэцэг) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд даалгасугай.

ДАРГА

Л.ОЧ



*сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит  
дөрөвдүгээр хуралдааны 2025 оны 7 дугаар  
сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолын  
хавсралт*

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ**

Д/д	Малын төрөл	Ногдох албан татвар
1	2	3
1	Адуу	450
2	Үхэр	250
3	Хонь	250
4	Ямаа	350
5	тэмээ	0

## **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 9 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 5/5

Баяндалай сум

### **ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨР ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, Сангийн сайд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баяндалай сумын нутаг дэвсгэр дээр үйлчлэх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Уг тогтоолыг зохих хууль журмын дагуу холбогдох газарт бүртгүүлж, үйлчилгээний хураамжийг дагаж мөрдүүлэн, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга (У.Буян-Өлзий), Татварын Улсын байцаагч (С.Баттогтох) нарт даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 4/15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА:

Б.НАРМАНДАХ

**Өмнөговь аймгийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн  
5/5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт**

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

№	Үйлчилгээний төрлүүд	Хэмжих нэгж	Хураамж /төг/
1	Төсөвт байгууллага	Сард /Жилд	5000 /60000
2	Сумын төвийн айл өрх болон төв суурин газрын ойролцоо бүсэд байгаа малчин өрх	Сард /Жилд	1000 /12000
3	Хөдөөгийн малчин өрх	Сард /Жилд	500 /6000
4	Аж ахуйн нэгж /үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар/	Сард /Жилд	5000 /60000
5	Худалдааны цэгүүд, дэлгүүр, бичил уурхай	Сард /Жилд	2000 /24000
6	Зочид буудал	Сард /Жилд	2000 /24000
7	Хоол үйлчилгээний газар	Сард /Жилд	2000 /24000
8	Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ	Сард /Жилд	12500 /150000

*Өмнөговь аймгийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн  
5/5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

№	Үйлчилгээний төрөл	Нэгж	Зардлын нэгж тарифийн хэмжээ /төгрөг/
1	Энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх	Тонн/төгрөг	53250

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 7359 дүгээрт бүртгэв.

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 50

Баянхонгор хот

### ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3, Захиргааны ерөнхий хуулийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоол, “Рашаант хайрхан” ХХК-ийн 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Рашаант хайрхан” ХХК-ний эзэмшлийн дулаанаар түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөсүгэй.

3.Батлагдсан тарифыг мөрдүүлж, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийг халаалт, дулаанаар найдвартай ханган ажиллахыг “Рашаант хайрхан” ХХК-ний гүйцэтгэх захирал /Л.Баярмаа/-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга, орон тооны бус гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дугаар мөрөнд байх “Рашаант хайрхан” ХХК-ний үнэ тарифтай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ТҮВШИНБИЛЭГ

ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮН

М.МӨНХБАТ

*Баянхонгор аймгийн Эрчим хүчний  
зохицуулах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр  
сарын 10-ны өдрийн 50 дугаар  
тогтоолын хавсралт*

**БАЯНХОНГОР СУМЫН “РАШААНТ ХАЙРХАН” ХХК-ИЙН  
ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН  
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

№	Хэрэглэчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллага-д борлуулах дулааны тариф:		
	Хэмжүүрээр тооцох тариф	Төг/Гдж	51105.6
	Эзэлхүүнээр тооцох тариф	Төг/м <sup>3</sup>	2360.0
2	Үйлдвэр, Аж ахуйн нэгж байгууллага-д борлуулах дулааны тариф:		
	Хэмжүүрээр тооцох тариф	Төг/Гдж	25552.8
	Эзэлхүүнээр тооцох тариф	Төг/м <sup>3</sup>	2140.0
3	Айл өрх-д борлуулах дулааны тариф:		
	Хэмжүүрээр тооцох тариф	Төг/Гдж	7850.9
	Эзэлхүүнээр тооцох тариф	Төг/м <sup>2</sup>	450.0



*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд  
2025 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хүлээн авсан.*

## **СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙДЫН ТУШААЛ**

2025 оны 4 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар А/124

Улаанбаатар  
хот

### **ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1/785 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” А/22 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Оюунбилэг)-т үүрэг болгосугай.

САЙД

Ч.НОМИН

## ТЭМДЭГЛЭЛ